



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2021 он



Хөрөнгийн зах зээлийн тойм

Өндөр хөгжилтэй орнуудын хувьцааны зах зээл энэ онд өсөлттэй байж хөрөнгө оруулагчид гуравдах жилдээ хувьцааны зах зээл дээрээс өндөр өгөөж хүртлээ.



Өнгөрсөн хугацааны гүйцэтгэл нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа биш болно.

Эх сурвалж: BlackRock Investment Institute, 2021 оны 12 сар.

Тэмдэглэл: Баганаан график нь 2021 оны хамгийн их өсөлт, бууралтын хязгаарыг илэрхийлэх бөгөөд цэгэн мэдээлэл нь оны эхнээс өнөөдрийг хүртэлх өгөөжийн хэмжээг илэрхийлнэ.


Ашигласан үзүүлэлтүүд: Brent нефтийн спот ханш, MSCI Europe Index, MSCI USA Index, ICE USD Dollar Index (DX), Bank of America Merrill Lynch Global өндөр өгөөжийн индекс, MSCI хөгжиж буй зах зээлийн индекс, JP Morgan EMBI индекс, Refinitiv Datastream Итали 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын индекс, Bank of America Merrill Lynch Global Broad Corporate индекс, Refinitiv Datastream Герман 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын индекс, Refinitiv Datastream АНУ-ын Засгийн газрын бондын 10 жилийн жишиг индекс болон алтны спот ханш.



Дэлхийн хувьцааны зах зээлийн хувьд 2021 он өсөлтийн жил байлаа. Ковид-19-ийн шинэ хувилбарууд цар тахлын үргэлжлэх хугацааг уртасгаж, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал болон инфляцын өсөлт хувьцааны зах зээлд сөргөөр нөлөөлсөн ч 2021 онд хөрөнгө оруулагчдын итгэл алдарсангүй. Холбооны Нөөцийн Сан (ХНС) бодлогын хүүгээ тэгтэй ойр байлгаж, их хэмжээгээр долларын нийлүүлэлт хийсэн нь хөрөнгө оруулагчдыг хувьцаа гэх мэт өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийхэд түлхэц болжээ. S&P 500 индекс 26.9%, Dow Jones Industrial Average индекс 18.7%, Nasdaq индекс 21.4% өссөн байна. Түүнчлэн, S&P 500 индекс 2021 онд бүх цаг хугацааны түүхэн дээд амжилтаа 70 удаа шинэчилсэн байна.

2021 оны 1-р сард видео тоглоомын GameStop (NYSE:GME) компанийн хувьцаа 1,700% өссөн бол AMC Entertainment Holdings (NYSE:AMC) 800% орчим өсөж бүх цаг үеийн дээд цэгтээ хүрч, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байсан бол оны сүүл гэхэд 2021 оны эхэн үеийн ханш дээр эргэн иржээ.


Хувьцааны зах зээл vs Бондын зах зээл, жилийн өгөөж, 1977-2021



Эх сурвалж: BlackRock Investment Institute, 2021 оны 12 сар.

Тэмдэглэл: Зурагт 1977-2021 оны дэлхийн хувьцааны болон бондын зах зээлийн ам.доллараар илэрхийлэгдэх жилийн өгөөжийг харуулсан. Хувьцааны зах зээлийг MSCI All-Country World индексээр (1988 оноос өмнөх үзүүлэлтэд MSCI World), бондын зах зээлийг Bloomberg Global Aggregate (1991 оноос өмнөх үзүүлэлтэд U.S Aggregate) индексээр төлөөлүүлсэн болно.

АНУ-ын инфляц, банк хоорондын захын хүү, таамаглал, 2000-2025



Таамаглалууд биелэхгүй байх боломжтой болно

Эх сурвалж: BlackRock Investment Institute, U.S. Bureau of Labor Statistics, Bloomberg, Холбооны нөөцийн сан, 2021 оны 12-р сар

Тэмдэглэл: АНУ-ын инфляцын таамаглал нь BlackRock Investment Institute-ийн таамаглал болно. ХНС-ын түүхэн хариу үйлдэл нь инфляцын хэмжээнд харгалзах бодлогын хүү болон гарцын хэмжээний түүхэн голч болно. Банк хоорондын захын хүүгийн таамаглал нь зах зээлийн хүлээлт болно.

2021 оны 4-р сараас хойш Microsoft (NASDAQ: MSFT), Google (NASDAQ: GOOG), Apple (NASDAQ: AAPL), Nvidia (NASDAQ: NVDA) болон Tesla (NASDAQ: TSLA) гэсэн нийт 5 компанийн хувьцаа, S&P 500 индексийн өсөлтийн 51%-ийг дангаараа бүрдүүлсэн байна. 2021 оны эхэн үед S&P 500 индексийн сагсанд багтах хувьцаануудын 90% гаруй нь сүүлийн 200 хоногийн дундаж үнээсээ дээгүүр арилжаалагдаж байсан бол оны сүүлийн хагаст S&P 500 индексийн сагсанд багтах хувьцаануудын 60% орчим нь сүүлийн 200 хоногийн дундаж үнээсээ доогуур арилжаалагдсан байна.

Цаашлаад криптовалютын зах зээлийн үнэлгээ энэ онд 3 дахин нэмэгдэж, хувь хөрөнгө оруулагчид, томоохон групп компани болон санхүүгийн байгууллагуудын анхаарлын төвд орж эхэлсэн. Ялангуяа "meme" маягаар гарч ирсэн "Doge" болон "Shiba Inu" гэх мэт койнууд нь зах зээл оролцогчдын анхаарлын төвд орж, огцом өсөлтийг үзүүлжээ.

2021 онд хөрөнгө оруулагчдын анхаарлыг татсан бас нэгэн үзүүлэлт нь инфляцын түвшин юм. Цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн улс орнуудын эдийн засгийг дэмжих бодлогын үр дүнд ихэнх улс орнуудад инфляцын хэмжээнд өсөлт гарсан байна. АНУ-д гэхэд инфляцын түвшин 2021 онд 6.8%-д хүрсэн нь 1982 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Инфляцын өсөлт нь эдийн засаг болон хөрөнгийн зах зээлд хэрхэн нөлөөлөх талаар хөрөнгө оруулагчид санаа зовж байсан ч

инфляцын түвшин нэмэгдсэн нь хэрэглэгчдийн эрэлтийн хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн сэргэлт явагдахад түлхэц болсон байна. Ялангуяа, эдийн засгийн гуравны хоёрыг нь хувийн хэрэглээ эзэлдэг АНУ-д эдийн засгийн сэргэлт хурдацтай явагдсан байна.

Гэхдээ, 2021 оны 12 сарын хэрэглэгчдийн итгэлийн судалгаагаар АНУ-ын иргэдийн итгэл цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байгааг харуулжээ. Мөн тус судалгаанд, АНУ иргэдэд инфляцын өсөлт тааламжгүй байгаа ч хэрэглээгээ нэмэгдүүлж байгаа тухай мэдээлсэн байна.

Цаашлаад 2021 онд АНУ-ын ажилгүйдлийн түвшин 4.2% хүртэл буурч, хөдөлмөрийн зах зээлийн сэргэлт онцгой анхаарал татаж байна. АНУ-д 2020 оны 4-р сараас хойш 18.5 сая ажлын байр нэмэгдэж, ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо сүүлийн 52 жилийн доод түвшинд хүрсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал болон инфляцын өсөлтийн хэмжээ нь ХНС-г илүү хатуу мөнгөний бодлого баримтлахад түлхэц болж байна. ХНС-аас 2022 оны 3-р сар гэхэд бондын худалдан авалтаа зогсоохоор төлөвлөж байгаа ба инфляцыг хэмжээг бууруулахын тулд 2022 онд зорилтот хүүгийн хэмжээгээ гурван удаа нэмэгдүүлэх боломжтой гэж мэдэгдэв. ХНС-гийн бондын худалдан авалтын хөтөлбөр дуусгавар болоход эдийн засгийн өсөлт болон хувьцааны зах зээлийн өсөлт үргэлжлэх хэвээр эсэхэд хөрөнгө оруулагчид гол анхаарлаа хандуулж байна.

АНУ-ЫН
ХҮҮГИЙН
ТҮВШИН

АНУ-ын Холбооны Нөөцийн Сангаас (ХНС) богино хугацааны инфляцын хүлээлтээ нэмэгдүүлээд байсан ба АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал сайжирч байгаа тул ихэнх шинжээчид бодлогын хүү нэмэгдэх боломжтой болсон гэж үзэж байна. Цар тахалтай холбоотой 2020 оны эхэн үед АНУ-ын хөдөлмөр эрхлэлтийн түвшин огцом уналт үзүүлээд байсан ч сүүлийн үед нэг талаас эдийн засгийн сэргэлтээс хамааран нөгөө талаас тэтгэвэрт гарах, ажил хайхаа болих гэх мэтээр хөдөлмөрийн зах зээлээс гарч буй иргэдийн тоо нэмэгдэж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдэхэд нөлөөлж байна. Тиймээс ХНС-аас хөдөлмөрийн зах зээлийн зорилтдоо хүрсэн гэж үзэн, хүүгийн хэмжээг нэмэгдүүлэх магадлал өндөр байгаа тухай ихэнх шинжээчид мэдээлж байна.

Зах зээлийн үзүүлэлт 2021.12

ИНДЕКС	ХААЛТ	САРЫН ӨӨРЧЛӨЛТ	УЛИРЛЫН ӨӨРЧЛӨЛТ	ОНЫ ӨӨРЧЛӨЛТ
Бүс нутгийн хувьцааны индекс (MSCI)				
MSCI World Index	3,231.73	4.2%	7.5%	20.1%
MSCI USA	4,593.60	3.8%	9.7%	25.2%
MSCI Europe ex-UK	2,637.37	6.4%	5.4%	13.7%
MSCI UK	1,174.53	7.1%	5.1%	13.9%
MSCI Japan	3,851.46	1.8%	-4.1%	-0.1%
MSCI AC Asia ex-JP	789.28	1.2%	-1.5%	-6.4%
MSCI EM Latin America	2,129.86	4.6%	-4.4%	-13.1%
MSCI EM (Emerging Markets)	1,232.01	1.6%	-1.7%	-4.6%
Жишиг зах зээлүүдийн хувьцааны индекс				
MSE Top20	44,411.60	12.8%	3.4%	130.3%
Dow Jones	36,338.30	5.4%	7.4%	20.2%
S&P 500	4,766.18	4.4%	10.6%	28.8%
Nasdaq	15,644.97	0.7%	8.3%	23.2%
S&P/TSX	21,222.84	2.7%	5.7%	21.1%
FTSE 100	7,384.54	4.6%	4.2%	12.4%
S&P/ASX 200	7,444.60	2.6%	1.5%	11.4%
Nikkei 225	28,791.71	3.5%	-2.2%	5.6%
Hang Seng	23,397.67	-0.3%	-4.8%	-14.8%
Жишиг зах зээлүүдийн бондын индекс				
Bloomberg Barclays Global Aggregate	532.43	-0.1%	-0.7%	-4.8%
Bloomberg Barclays US Aggregate	2,355.14	-0.3%	0.0%	-1.5%
Bloomberg Barclays Japan Aggregate	141.00	-0.2%	-0.1%	-0.2%
Bloomberg Barclays UK Aggregate	303.05	-2.3%	2.0%	-4.7%
Bloomberg Barclays Euro Aggregate	263.64	-0.1%	-0.7%	-1.0%
Монгол бондууд				
	Өгөөж*			
Mongol 2024 (Хуралдай)	3.68%	-0.3%	1.5%	0.5%
Mongol 2023 (Гэрэгэ)	3.22%	-0.3%	1.4%	0.2%
Mongol 2022 (Чингис)	2.57%	-0.1%	2.5%	-0.3%
DBM' 23 (Самурай)	0.03%	0.0%	-3.6%	-0.9%
DBM' 2023	3.94%	-0.1%	-3.0%	-0.1%
MGMTGE' 2022 (Өүлэн)	4.13%	-1.5%	0.3%	-5.5%
Mongol 2026 (Номад)	4.47%	-0.1%	-4.8%	0.9%
MGMTGE' 2024	10.39%	0.1%	-3.4%	10.4%
MMC' 2024	19.08%	0.8%	15.1%	6.7%
Mongol 2027	4.63%	-0.1%	-0.2%	4.6%
Mongol 2031	5.14%	-0.1%	5.1%	5.1%

Эх сурвалж: Bloomberg, Bloomberg Barclays, MSCI, J.P. Morgan Asset Management. 2021 оны 12 сар.
Тэмдэглэл: *Бондын дуусах хугацаа хүртэл эзэмжих өгөөжийн түвшин. (жилийн)

Монгол улсын макро үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	2020.XI	2021.X	2021.XI	ЖИЛ	САР
Инфляцийн түвшин	3.50%	9.70%	10.50%	7.00%	0.80%
Бодлогын хүү	6.00%	6.00%	6.00%	0.00%	0.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	7.17%	6.07%	6.08%	-1.09%	0.01%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	10.59%	7.19%	7.10%	-3.49%	-0.09%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	3.69%	2.25%	2.10%	-1.59%	-0.15%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	16.75%	15.71%	15.60%	-1.15%	-0.11%
Зээлийн дундаж хүү /валют/	10.46%	9.31%	9.30%	-1.16%	-0.01%

Эх сурвалж: Монголбанк, мөнгө, санхүүгийн статистикийн бюллетень, 2021 оны 12-р сарын 19-ны өдрийн мэдээлэл

Тэмдэглэл: Сонгосон үзүүлэлтүүдийн сарын эцсийн дүнгүүдийн жилийн болон сарын өөрчлөлтүүдийг харгалзан харуулж байгаа болно. Төгрөг болон валютаарх хадгаламжийн болон зээлийн дундаж хүүг тухайн сарын үлдэгдэл дээр тооцсон мэдээллийг ашигласан.




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2021 он Монголын хөрөнгийн зах зээлд ээлтэй жил байлаа. Өмнөх оны эцэстэй харьцуулахад Монголын Хөрөнгийн Биржийн (МХБ) индексүүд энэ оны төгсгөлд бүгд өсөлттэй байсан буюу ТОП 20 индекс 130.3%-аар, MSE A индекс 69.7%-аар, MSE B индекс 61.0%-аар тус тус өсөлттэй байлаа. Цаашлаад, МХБ-д бүртгэлтэй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ өмнөх онтой харьцуулахад 98%-аар өсөж 5.98 их наяд төгрөг хүрээд байна.

Түүнчлэн, энэ онд 37 компани нийт 161.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 6%-аар өссөн үзүүлэлт болжээ.

Мөн энэ онд Bloomberg агентлагаас Монголын хөрөнгийн зах зээлийг дэлхийн хамгийн өсөлттэй зах зээл хэмээн онцлоод байгаа ба FTSE Russell группээс Монголын хөрөнгийн зах зээлийг 2021 оны 9-р сард "Хөгжиж буй зах зээл"-ийн "Ажиглалтын жагсаалт"-д оруулаад байгаагаа мэдээлсэн байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн I ангилалд бүртгэлтэй компаниудаас "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн (MSE: AARD) хувьцаа 456.60%-аар, "Түмэн Шувуут" ХК-ийн (MSE: TUM) хувьцаа 300.12%-аар, "АПУ" ХК-ийн (MSE: APU) хувьцаа 198.11%-аар өсөж ханшийн өсөлтөөр тэргүүлээд байна.


МХБ-ийн нийт зах зээлийн үнэлгээний 32.1%-ийг буюу 1,917.6 тэрбум төгрөгийг "АПУ" ХК, 6.7%-ийг буюу 397.9 тэрбум төгрөгийг "Таван Толгой" ХК, 5.2%-ийг буюу 310.4 тэрбум төгрөгийг "МИК Холдинг" ХК, 4.9%-ийг буюу 290.0 тэрбум төгрөгийг "Инвекор ББСБ" ХК, 4.9%-ийг буюу 278.0 тэрбум төгрөгийг "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК эзэлж байгаа бол бусад МХБ-д бүртгэлтэй 180 хувьцаат компани нийт зах зээлийн үнэлгээний 46.5%-ийг буюу 2,783.1 тэрбум төгрөгийг эзэлж байна.

"Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК (MSE: CUMN) IPO хийх замаар 9,643 хөрөнгө оруулагчаас 28.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэнд хамгийн олон хөрөнгө оруулагч оролцсон IPO болсон байна.

БАНКНЫ РЕФОРМ

2021 оны 12-р сард "Богд Банк" ХК (MSE: BOGD) нийт хувьцааны 20 хувь буюу 12,500,000 ширхэг хувьцааг нэг бүр нь 2,540 төгрөгөөр санал болгон гаргаж, нийт 31.75 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх замаар банкны салбарын реформын хүрээнд хувьцаат компани болж буй анхны банк боллоо. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 70% нь стратегийн хөрөнгө оруулагч нарт, үлдсэн 30% нь олон нийтэд санал болгосон ба тус компанийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 1,243 хувь хүн, аж ахуйн нэгж оролцсон байна.

МХБ-ийн үнэт цаасны арилжаа




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

"Богд Банк" (MSE: BOGD) 2021 оны 12-р сард IPO хийн банкны салбарын реформын хүрээнд хувьцаат компани болж буй анхны банк боллоо.

2021 онд МХБ дээр 4 компаниас нийт 720.1 тэрбум төгрөгийн нээлттэй бонд гарсан ба тэдгээрээс, "Эрдэнэ Тавантолгой" ХК дэд бүтцийн болон стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготойгоор дотоодын зах зээлийн түүхэнд хамгийн өндөр үнийн дүн бүхий төгрөг болон ам.доллар хосолсон нийт 2 их наяд төгрөг хүртэлх дүнтэй бондын хөтөлбөр гарсан нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байгаа юм.

Үнэт цаасны арилжааны хувьд, МХБ дээр 2021 онд хувьцаа, Хөрөнгө Оруулалтын Сангийн (ХОС) нэгж эрх, компанийн бонд болон Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас (ХБҮЦ) гэсэн 4 төрлийн үнэт цаас нийт 1,411.2 тэрбум наяд төгрөгөөр арилжаалагдсан байна. Үүнээс, хувьцааны арилжаа 21.6%-ийг буюу 304.9 тэрбум, ХОС-гийн нэгж эрхийн арилжаа 4.0% буюу 56.8 тэрбум, компанийн бондын арилжаа 74.1% буюу 1,048.2 тэрбум, харин ХБҮЦ-ны арилжаа 0.3%-ийг буюу 4.2 тэрбум төгрөгийг эзэлж байгаа юм. 2021 оны 4-р сар, 8-р сар болон 11-р сард арилжааны хэмжээ бусад саруудтай харьцуулахад огцом өсөлттэй байсан ба энэхүү өсөлт нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бондын хөтөлбөрийн хүрээнд гарч буй компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой байлаа.



Эх сурвалж: Монголын Үнэт Цаасны Арилжааны Эрхлэгчдийн Холбоо

Тэмдэглэл: 36 сарын хугацаатай 6.8%-ийн хүүтэй бонд нь ам.долларын бондууд болно

2021 оны 9-р сард Монгол улсад биржийн бус зах зээлийн арилжаа албан ёсоор эхэлсэн билээ. Үүнээс хойш биржийн бус зах зээл дээр 22 компани нийт 285.7 тэрбум төгрөгийн бонд гаргаад байгаа юм. Биржийн бус зах зээл дээр гарсан бондуудыг хугацааны хувьд авч үзэхэд 3 сарын хугацаатай 2 бонд, 12 сарын хугацаатай 19 бонд, 18 сарын хугацаатай 4 бонд, 24 сарын хугацаатай 4 бонд, 36 сарын хугацаатай 2 бонд тус тус гараад байна. Түүнчлэн биржийн бус зах зээл дээр "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК-аас жилийн 6.8%-ийн хүүтэй 36 сарын хугацаатай анхны ам.долларын бондыг гаргаад байна.

Нийтлэлийг бэлтгэсэн:

ТАНЫ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДИЖИТАЛ ХӨТӨЧ



Вэб: www.tdbsecurities.mn

Имэйл: info@tdbsecurities.mn

Утас: 70100261, 70100263

"МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК" ХХК



"Монголын Ипотекийн

Корпораци ОССК"

ХХК нь биржийн бус зах зээл дээр 50 сая

ам.доллар хүртэл үнийн дүн бүхий

өрийн бичгийн хөтөлбөрийг

бүртгүүлээд байна. Тус хөтөлбөрийн

хүрээнд эхний транч 2021 оны

12-р сард 36 сарын хугацаатай 6.8%-ийн

хүүтэй гараад байна. Ийнхүү тус компани

дотоодын зах зээл дээр ам.долларын

бонд гаргасан хамгийн анхны

олон улсын зээлжих зэрэглэлтэй компани

болоод байгаа ба тус компанийн зээлжих

зэрэглэл нь Монгол улсын зээлжих

зэрэглэлтэй ижил түвшинтэй байгаа

юм.